



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар

А/102

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 84 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 03 тоот албан даалгавар, Засгийн газрын Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 221 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн нөөцийн 2021-2022 оны өвс бэлтгэлд зориулан Булган сумын хадлангийн механикжсан салаанд бэлтгэсэн өвсийг Булган голоос Бүрэнхайрхан багийн төвд тээвэрлэхэд зориулсан шатахууны зардал болох 1.705.000 төгрөг (нэг сая долоон зуун таван мянган)-ийг хавсралтаар баталгасугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1.705.000 төгрөгийг аймгийн өвс, тэжээлийн нөөцийн санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.


3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 04-ний өдрийн
А/102 дугаар захирамжийн хавсралт



“Булган голоос Бүрэнхайрхан багийн төвд хадлангийн механикжсан
салааны өвс татахад зориулан гарах шатахууны зардлын тооцоо

№	Механикжсан салаа сумдад	Шатахууны зардал төгрөгөөр	Тоо ширхэг /Пресс/	1 литр дизель
1.	Булган сум Булган голын ай саваас Бүрэнхайрхан багийн төв	1.705.000	3000	2900 л
Нийт				1.705,000

-oOo-